*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны*
*98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХШҮХ-ИЙН ОРОН НУТГИЙН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.ПҮРЭВМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Нэг. “Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлага, албан хаагчдыг бодлогын зөвлөмжөөр хангах, төрийн байгууллагуудад арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ №1.1** Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нар болон бусад байгууллагын дарга нартай байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үнэлгээний дүнг аймгийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулах. | Дүн шинжилгээ үнэн зөв хийгдсэн байх. | 9 агентлагийн дарга нарын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ХШҮ хийсэн | ХШҮ-г хийж, удирдлагад танилцуулагдсан байна. | 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан 9 агентлагийн дарга нарын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтэд 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийн үнэлгээний хуудсаар баталгаажуулан хүргүүлсэн. | 2024.11.30 2024.12.20 | 100% |



255

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Арга хэмжээ №1.2**<br>Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | Засгийн газрын гишүүнтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд ХШҮ хийсэн тоо | Засгийн газрын 7 гишүүнтэй байгуулсан гэрээний хэрэгжилт ХШҮ хийсэн | 7 | 2024 онд Засгийн газрын 7 гишүүнтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг журмын хавсралтын дагуу гаргаж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | 2024.11.10<br>2024.12.31 | 100% |
| 3. | **Арга хэмжээ №1.3**<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд тогтоосон хугацаанд хүргэгдсэн байна. | 2 удаа хүргэсэн | 2 | 2024 он эхний хагас жилийн байдлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 7, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 56, нийт 63 тогтоол бүртгэлтэй байна. Үүнээс хугацаа дууссан, хүчингүй болсон 14 тогтоолыг хяналтаас хасаж 49 тогтоолын хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж хувь 78.8 байна. 2024 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит болон Ээлжит бус хуралдааны 29 тогтоол, шийдвэрийг хяналтад авч, 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 53 тогтоол, шийдвэрийн биелэлтийг нэгтгэн ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 90% |
| ХОЁР.“НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, МЭДЭЭЛЖ ТАЙЛАГНАХ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАХ, ЧАДАВХЖУУЛАХ, ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ №2.1** Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг дарга түүний тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах. | Дүн шинжилгээ хийгдэж хуралд танилцуулагдсан байна. | Дүн шинжилгээ хийгдэж хуралд танилцуулсан. | 100% | Монгол улсын Засгийн газрын 2020 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" батлах тухай 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/750 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын дэргэдэх 25 агентлаг болон 2 сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд ХШҮ-г зохион байгуулав.<br>Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/178 дугаар захирамжаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Нийт 3 чиглэлийн 20 үзүүлэлтээр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн.<br>Аймгийн Засаг даргын дэргэдэх захиргааны байгууллага болон сумдын Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг нэгтгэж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2023 оны үйл ажиллагааны үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан 5 байгууллагыг | 2024.01.01<br>2024.04.31 | 100% |



241

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шилдгээр шалгаруулан тус бүр 3.0 сая төгрөгөөр аймгийн Засаг даргын 2022 оны А/750 дугаар захирамжаар баталсан журмын дагуу шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан. Мөн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс гарсан зөвлөмжийг байгууллага тус бүрээр гарган Засаг даргын албан тоотоор хүргүүлсэн. | | |
| 2 | **Арга хэмжээ №2.2** Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг болон сумдын ЗДТГ-ын ХШҮ-ний багийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэргэшил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх. | Зохион байгуулсан сургалтын тоо | 1 | 1 | “Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт сургалтын хүрээнд “Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх арга зүй” хичээлээр 2024 оны 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд 38 байгууллагын 68 албан хаагчдад хичээл заасан. | 2024.10.29 2024.11.15 | 100% |
| 3 | **Арга хэмжээ №2.3** Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцох, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн 3 талт | Хугацаанд нь тайлагнасан эсэх, биелэлтийн хувь | 93.2% | Хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг зохион байгуулж 3 талт байнгын хороонд танилцуулсан байна. | Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрт 7 бүлгийн 81 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хэрэгжилтийн дундаж 88.9 хувьтай байна. | 2024.01.01 2024.12.31 | 88.9% |



2442

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байнгын хороонд танилцуулах. | | | | | | |
| 4 | **Арга хэмжээ №2.4** Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагуудад танилцуулах. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн Засаг даргын захирамжийн тоо | 62 | 69 | 2024 онд аймгийн Засаг даргын 864 захирамж гарснаас, хэрэгжилт гарах 69 захирамжийг хяналтад авч хэрэгжилтийг хангуулж ажилласан. 2024 оны байдлаар нэгтгэл дууссаны дараа аймгийн удирдлагуудад танилцуулахаар ажиллаж байна. | 2024.01.01 2024.12.31 | 90% |
| 5 | **Арга хэмжээ №2.5** Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох байгууллага, албан тушаалтанд и-оффис системээр дамжуулан хүргэж, дараагийн шуурхай зөвлөгөөнд хэрэгжилтийг танилцуулах. | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | 89.1% | 94.7% | Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөн 2024 онд нийт 50 удаа хуралдаж, 347 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг нэгтгэн ажилласан байна. Хэрэгжилт 94.7 хувьтай байна. Шуурхай зөвлөгөөнөөс өгч байгаа үүрэг даалгаврын хэрэгжилтийн ирцийг тухай бүр бүртгэж байна. Үүрэг даалгаврын танилцуулгыг оны эхний 5 сарын байдлаар давтамж, ирц, хамгийн олон үүрэг даалгавар өгөгдсөн агентлаг, нийтлэг алдаа, анхаарах асуудал зэрэг агуулгаар бэлтгэсэн. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 6 | **Арга хэмжээ №2.6** Аймгийн Засаг даргын Тамгын газрын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох байгууллага, албан тушаалтанд и-оффис системээр дамжуулан хүргэж, дараагийн шуурхай зөвлөгөөнд | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | 93.7% | 94.1% | Аймгийн Засаг даргын тамгын газрын шуурхай хурал 2024 онд 46 удаа хуралдаж, 245 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг нэгтгэн ажилласан байна. Хэрэгжилт 94.1 хувьтай хэрэгжиж байна. Шуурхай зөвлөгөөнөөс өгч байгаа үүрэг даалгаврын хэрэгжилтийн ирцийг тухай бүр бүртгэж байна. Үүрэг даалгаврын танилцуулгыг оны эхний 5 сарын байдлаар давтамж, ирц, хамгийн олон үүрэг даалгавар | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг танилцуулах. | | | | өгөгдсөн агентлаг, нийтлэг алдаа, анхаарах асуудал зэрэг агуулгаар бэлтгэсэн. | | |
| 7 | **Арга хэмжээ №2.7** Хэлтсийн дарга нарын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох байгууллага, албан тушаалтанд и-оффис системээр дамжуулан хүргэж, дараагийн шуурхай зөвлөгөөнд хэрэгжилтийг танилцуулах. | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | 92.5% | 92.9% | Удирдлагын шуурхай зөвлөгөөн 2024 онд 34 удаа хуралдаж, 151 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг нэгтгэн ажилласан байна. Хэрэгжилт 92.9 хувьтай хэрэгжиж байна. Шуурхай зөвлөгөөнөөс өгч байгаа үүрэг даалгаврын хэрэгжилтийн ирцийг тухай бүр бүртгэж байна. Үүрэг даалгаврын танилцуулгыг оны эхний 5 сарын байдлаар давтамж, ирц, хамгийн олон үүрэг даалгавар өгөгдсөн агентлаг, нийтлэг алдаа, анхаарах асуудал зэрэг агуулгаар бэлтгэсэн. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| ГУРАВ. "ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БОДИТ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР УДИРДЛАГА, ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ №3.1** Аймгийн хэмжээнд батлан хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дэд хөтөлбөрийн тоо | 2 | 4 | 2 зорилт, 17 арга хэмжээ бүхий аймгийн Засаг дарга "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай 2023 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, 3 зорилт, 15 арга хэмжээ бүхий "Багийн хөгжлийг дэмжих" хөтөлбөр (91.8%), 3 зорилт, 37 арга хэмжээ бүхий "Залуучуудын хөгжлийн хөтөлбөр" (90.9%), 3 зорилт, 13 арга хэмжээ бүхий "Газрын харилцааны талаар 2024 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл" (91.8%)-үүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |



2ЧЧ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ №4.1** ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаал | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь үнэн, зөв гаргасан. | 90% | Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг үндэслэн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр боловсруулж, батлуулсан.<br>2024 оны 1 дүгээр улирлын байдлаар ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын дагуу "Ярилцлагын тэмдэглэл", "Нэмэлт үүрэг даалгаврын хуудас"-ыг хэлтсийн даргаар дүгнүүлэн ТЗУХ-ийн хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |
| 2. | **Арга хэмжээ №4.2** Төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах. | Ёс зүйн хэм хэмжээ зөрчөөгүй байх | Ёс зүйн хэм хэмжээ зөрчөөгүй байна | Ёс зүйн хэм хэмжээ зөрчөөгүй байна | Төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахиж Төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, аймгийн ЗДТГ-ын албан хаагчийн үйлчилгээний стандартыг чандлан мөрдөж, сахилгын шийтгэлгүй ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |
| 3 | **Арга хэмжээ №4.3** Төрийн албаны тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Монгол улсын хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг албаны үйл ажиллагаа явуулахдаа хэрэгжүүлэх, хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг чанд мөрдөн ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол улсын их хурлын хяналт шалгалтын тухай болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | | | | | | |
| 4 | **Арга хэмжээ №4.4** Хөтлөгдөж дууссан баримт бичгийг албан архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу цэгцэлж байгууллагын архивт хүлээлгэн өгөх. | Зааврын дагуу цэгцэлж хүлээлгэн өгсөн байх. | 13 | 100% | ХШҮХ-ийн 2023 оны 9 баримт бичгийг ТЗУХ-ийн архив, бичиг хэргийн эрхлэгчид жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан. Мөн 2020, 2021, 2022 онуудын үүрэг даалгаврын биелэлтийн 2 баримт, төрийн байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 5 баримтыг үдэхэд бэлэн болгосон. | 2024.01.01 2024.12.31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**



246

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Албан хаагчдын хүүхдүүдэд зориулж арга хэмжээ зохион байгуулах, "Байгууллагын эцэг эхийн зөвлөл"-ийн ажлын хэсэгт ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/28 дугаарт тушаалаар батлагдсан "Байгууллагын эцэг эхийн зөвлөл"-ийн ажлын хэсэгт ажиллаж, 2024 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгууллагын албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан сугалаа, бэлэг гардуулах арга хэмжээг зохион байгуулсан. | 2024.05.15 2024.05.27 | 100% |
| 2 | 2023 оны эд хөрөнгийн тооллогын дүнг umch.gov.mn программд оруулах. | Бүрэн алдаагүй оруулсан байх | 1 | 1 | 2023 оны жилийн эцсийн байдлаар тоологдсон 113 нэр төрлийн 751 ширхэг 1579.6 сая төгрөг, 33 нэр төрлийн 661 ширхэг 332.2 сая төгрөгийн тавилгыг umch.gov.mn программд оруулсан. | 2024.03.01 2024.03.07 | 100% |
| 3 | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль болон Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдэвт сургалтыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах. | Хариуцсан ажлаа хийх | - | 1 | 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль болон Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдэвт сургалтад хамрагдах албан хаагчдад мэдээлэл хүргэх, бүртгэх ажлыг хариуцсан хийсэн. | 2024.05.01 2024.05.04 | 100% |
| 4 | Цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг бэлтгэн тухай бүрд нь холбогдох байгууллага, албан тушаалтад хүргүүлэх. | Хариуцсан ажлаа хийх | 1 | 1 | Орхон аймгийн товч танилцуулга болон 2020-2024 оны ажлын үр дүнгийн талаар мэдээллийг бэлтгэн холбогдох хэлтэс, албан тушаалтанд хүргүүлсэн. | 2024.05.30 2024.05.31 | 100% |
| 5 | Улсын их хурлын болон орон нутгийн сонгуулийн хэсгийн хороодод ажиллах. | Хариуцсан ажлаа хийх | 1 | 2 | 2024 оны 06 дугаар сард болсон Улсын их хурлын сонгуулийн 42 дугаар хэсгийн хороо, 2024 оны 10 дугаар сард болсон | 2024.06.01 2024.10.12 | 100% |



247

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Орон нутгийн сонгуулийн 13 дугаар хэсгийн хороодод ажилласан. | | |
| 6 | Төрийн албаны зөвлөлийн 2024 оны "Хүний нөөцийн аудит хийх мэдэгдэл, чиглэл хүргүүлэх тухай" 03/1983 дугаар албан бичгийн дагуу аудитын багтай хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах. | Хариуцсан ажлаа хийх | - | 1 | Аудитад хамрагдах байгууллагад холбогдох мэдээллийг хүргэж, хувийн хэрэг хүлээн авч, мэдээллийг нягталсны дараа буцаан олгосон. ТАЗ-өөс Мэдээлэл технологийн албан хаагчдын хүний нөөцийн аудит хийж байгаатай уялдуулан Мэдээллийн технологийн албан хаагчдын мэдлэгийн түвшин тогтоох сорил шалгалтыг цахимаар авах үйл ажиллагаанд оролцсон. | 2024.09.20<br>2024.10.05 | 100% |
| 7 | Удирдлагын академиас зохион байгуулж байгаа танхим, цахим хосолсон сургагч багш бэлтгэх "Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт сургалтад хамрагдаж, сургагч багшийн үнэмлэх аван аймагтаа танхимын сургалт зохион байгуулах. | Сургалт зохион байгуулах | - | 1 | "Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт сургалтын хүрээнд "Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх арга зүй" хичээлээр 2024 оны 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд 38 байгууллагын 68 албан хаагчдад хичээл заасан. | 2024.10.29<br>2024.11.15 | 100% |
| 8 | Аймгийн Засаг дарга, ЗДТГ-т иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, дүгнэлтийг аймгийн Засаг даргад танилцуулах. | Хариуцсан ажлаа хийх | - | 15 | 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн долоо хоногт 2 удаа албан бичиг ирсэн бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, дүгнэлтийг аймгийн Засаг даргад танилцуулсан. | 2024.11.01<br>2024.11.15 | 90% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |



248

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 1.** Шинээр батлагдан гарсан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шаардлагатай хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа ашиглах. | Үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах | Үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. | Үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах. | • 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр “Соёлыг түгээе” сургалтад хамрагдсан.<br>• 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр “Update+Сайнаас суралцъя” сургалтад хамрагдсан.<br>• 2024 оны 05 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд “Бодлогын баримт бичгийг үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх, аймгийн жилийн төлөвлөлт, төсвийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулах” сургалтад хамрагдсан. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 2 | **Арга хэмжээ 2.** Удирдлагын академиас “Төрийн албан хаагчийн тогтолцоог сайжруулах” ажлын хүрээнд зохион байгуулж байгаа цахим сургалтад хамрагдаж, үнэмлэх авах. | Сургалтад хамрагдах | - | 50% | Удирдлагын академиас “Төрийн албан хаагчийн тогтолцоог сайжруулах” ажлын хүрээнд зохион байгуулж байгаа цахим сургалтын эхний 3 “Алсын хараа 2050”, “Хүний эрх”, “Авлигаас ангид төрийн алба” сэдвийг цахимаар судалсан. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 3 | **Арга хэмжээ 3.** Удирдлагын академиас зохион байгуулж байгаа танхим, цахим хосолсон сургагч багш бэлтгэх “Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт сургалтад хамрагдаж, үнэмлэх авах. | Сургалтад хамрагдах | - | 100% | Удирдлагын академиас зохион байгуулж байгаа “Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт сургалтад цахимаар 2024 оны 10 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд, танхимаар 2024 оны 11 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд хамрагдаж 714805 дугаартай үнэмлэх авсан. | 2024.10.29 2024.11.13 | 100% |
| 4 | **Арга хэмжээ 4.** Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 | Сургалтад заасан мэдээлли | Жилийн туршид зохион байгуула | 50% | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7*4*10 цахим сургалтад 42 удаа хамрагдсан. Үүнд: ТАЗ-өөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл ба Цэгцрэх хөдөлгөөн”, | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим сургалтад хамрагдах. | йг бүрэн авах. | гдсан сургалтад хамрагдаж мэдээлэл авсан. | | “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагыг бэхжүүлэх нь”, “Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх эрх зүйн зохицуулалт, авч буй арга хэмжээ”, “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”, “Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага” гэх мэт. | | |
| 5 | **Арга хэмжээ 5.** Монгол бичгийн анхан шатны сургалтад хамрагдах. | Хамрагдсан сургалтын давтамж | 5 | 10 | Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Монгол бичгийн сургалтад 10 удаа хамрагдсан. | 2024.01.01 2024.12.31 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХШҮХ-ийн мэргэжилтэн (Албан тушаал)

М.Пүрэвмаа /.............................../ (Нэр, гарын үсэг)

2024.12.04 (Огноо)